

ТЭРГҮҮН

**МАХН-ЫН ТӨВ ХОРООНЫ V БҮГД
ХУРАЛ БА ТҮҮХИЙН АСУУДАЛ**

МАХН-ын Төв Хорооны V бүгд хурал (1988 оны 12-р сар) шинэ сэтгэлгээний үүднээс нам улсын амьдралын бүх салаа мөчирт өөрчлөн байгуулалтыг өрнүүлж, нэг хүнийг тахин шүтэж байсан үеийн уршгаас түүх, нийгэм судлал, ер нь шинжлэх ухааныг ангижруулан асуудлыг бодитой авч үзэх чиг шугамыг зааж өгсөн онцгой ач хол богдолтой үйл явдал болсон билээ.

Энэ бол дэлхий дахинаар өрнөж байгаа өөрчлөн байгуулалтын нэг хэсэг мөн бөгөөд түүний эрч хүчийг сааруулахгүй, тэтгэн лавшруулж байх явдал чухал байна.

ЗХУ-д ЗХУКН-ын Төв Хороо, нөхөр Михаил Сергеевич Горбачевын санаачилгаар эхэлсэн өөрчлөн байгуулалт тус оронд нийгэм эдийн засгийн бүх системийг шинэчлэн өөрчилж, Сталины аллага таллага, Брежневийн зогсонги үеэс үлдсэн бүхий л хог буртгаас өмнөх замаа цэвэрлэж, нэг хүнийг тахин шүтэж байсан жилүүдэд социализмын нүүр царай ихэд бурангуй болсныг засч залруулан, түүний чухамхүү ленинч мөн чанарыг сэргээж байгаагаар үл барам, орчин үеийн дэлхий дахины амьдрал, олон улсын харилцааны нийт системд аятай сайхан нөлөө үзүүлж байна.

Дэлхийн улс гүрнүүд бодлогоо одоогийн өөрчлөгдөн ахуй олон улсын байдалд зохицуулан шинэ сэтгэлгээний үүднээс хянан үзэх болж байна.

Марксист-түүхчин, ер нь бодитой сэтгэгч аливаа нэг түүхч эрдэмтний эн тэргүүний үүрэг бол түүх ба орчин үеэ сайн муу талтай нь үнэн мөнөөр судлан шинжилж, ирээдүйн магадтай чиг баримжааг тодорхойлон гаргах явдал мөн. Хүн нийгмийн нийгэм-эдийн засгийн хөгжил нь өөрийн зүй тогтолд захирагдах, зүй ёсны түүхэн үйл явдал мөн, гэхдээ өв тэгш, шулуун шугамаар явагддаггүй билээ.

Манай Монголд, мөн ЗХУ-д ч гэсэн, түүхийн шинжлэх ухаан, бусад шинжлэх ухааны нэг адил, ганц хүнийг тахин шүтэж байх үеэр ихээхэн хохирч, завхарч байлаа.

Намын зохион байгуулалт, үзэл суртлын ажлыг боловсронгуй болгох шинэ зорилтыг хэлэлцсэн МАХН-ын Төв Хорооны V бүгд хурлын үзэл санааны үүднээс түүхийн асуудлыг ямар ч ээдрээтэй байлаа ч гэсэн шинэ сэтгэлгээний үүднээс авч үзэх хэрэгтэй болж байна.

Социализм бол өөр бусад тодорхойлолтыг эс хэрэглэвэл, үнэн, шударга ёсыг хүндэтгэх нийгэм юм. Шинэ нийгмийн мөн чанарыг илтгэсэн энэхүү эрүүл саруул амьсгал В. И. Лениний амьд байхад зөвлөлт орны амьдралд гүнээ шингэж байжээ.

Монголд ч ардын хувьсгалын эхний жилүүдэд бас ийм байсан юм.

Гэтэл сүүлд Монголд Сталин, Чойбалсанг тахин шүтэх явдал газар авч, удтал үргэлжилж, ард түмний эсрэг цуст аллага таллага болон хувирч, социалист хууль ёс, хүний эрхийг бүдүүлгээр гуйвуулж, социалист нийгмийн хөгжилд үлэмж хор хөнөөл учруулав.

МАХН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, БНМАУ ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ж. Батмөнхөөс МАХН-ын Төв Хорооны V бүгд хурал дээр хэлэхдээ: «И. Сталин, Х.Чойбалсанг хэт өргөмжилж, ардчилал хязгаарлагдаж, захиран тушаах хүнд суртлын арга ноёрхож байсан бэрхшээлтэй үед Хувьсгалт хуулийг ийнхүү эрээ цээргүй завхаруулж байсан онц хортой буруу ажиллагааг Намын Төв Хорооны Тэргүүлэгчид нэг биш удаа авч үзэж, Чойбалсан өөрөө ч түүнийг ухаарсан дүр үзүүлж байсан боловч ямар ч тодорхой үр дүнд хүрээгүй, хууль завхруулах явдал улам газар авсан байна. Нам, ард түмэн ч нөхөшгүй их хохирол үзсэн байна» гэжээ.

Монгол орон феодализмаас социализмд капиталист бус замаар замнаж, өнөөдрийн нийгэм-эдийн засгийн хөгжлийнхөө түвшинд хүртлээ дардан замаар явж ирсэнгүй, ганц хүнийг тахин шүтэх явдлын хамаг муу муухайг амссан юм. Мөн Зөвлөлтийн шинэ нийгэм байгуулж буй сайхан туршлагыг механикаар хуулбарласнаас болж элдэв нугалаа завхралд өртөгдөж байлаа. Нам төрийн ямар ч гэм зэмгүй хэлмэгдсэн нэрт удирдагчдын орон гарсан тушаалд бодох сэтгэх нь болхи дорой, алсын хараагүй, арчаагүй этгээдүүд орцгоож, улс орны урагш давших хөдөлгөөнд чөдөр тушаа болж, улс төрийн эрүүл бус уур амьсгалаар ард түмнээ хордуулж, амь насыг нь хөнөөж байжээ.

Чойбалсан өөрийгөө тахин шүтүүлж, захиран тушаах хүнд суртлын арга хэрэглэж байсан нь улс төрийн шинжлэх ухаанаас, онолыг практикаас таслаж, бүр заримдаа ч утга учиргүй, инээдэмтэй байдалд хүргэж билээ. Үнэн байдлыг мушгин гуйвуулж, будаж шунхдаж, ажил хэрэгт шүүмжлэлтэй хандах нь байтугай, хувьсгалт хууль ёсыг балмадаар завхруулж байсан нь тус орны улс төр, нийгэм-эдийн засгийн байдалд хортой нөлөөлж, хөгжлийг нь хойш татсан билээ.

Манай нам, төрийн түүх ч ихээхэн гуйвж, завхарч, тус орны өнгөрсөн, одоо, ирээдүй нь, хэрэв хатуу эс хэлбэл, буруу зөрүү дүрслэгдэж байлаа.

Түүхийн шинжлэх ухаанд завхарч гуйвсаныг нь арилгаж, асуудлыг үнэн мөнөөр тавьж, энгийн шударга ёсыг сэргээн босгох явдал аль хэдийнээс үгүйлэгдэж байсан боловч, гагцхүү энэ тухай зүрхэлж хэлэх хэцүү, хэлбэл хэлмэгдэхээс зайлахгүй цаг байжээ. Хэдий тийш боловч манайд шинжлэх ухааны хөгжил бүр ч зогссонгүй, Чойбалсан, Сталиныг тахин шүтэх явдал ба түүний уршгаас болж үүссэн эрүүл бус нөхцөлд удаан боловч ахиж байжээ.

Эдүгээ ийм олон жил мөрөөдсөн үнэн шударга ёс талаар өнгөрсөнгүй, сая биелэлээ олж байна.

Монголын нийгэм судлаачдын өмнө түүхийн шинжлэх ухааныг өнгөрсөн үеийн хир буртаг, гуйвуулга завхруулгаас цэвэрлэн салгаж, түүний потенциалыг арвижуулан, практикийн өгөөжийг нь нэмэгдүүлэх эрхэм үүрэг хариуцлага зогсож байна.

Шинэ сэтгэлгээ бол аливаа асуудалд үнэний байр сууринаас шүүмжлэлтэй, бодитой хандаж байхыг хэлнэ. Ийм учраас түүхийн шинжлэх ухаан өөрчлөн байгуулалтын үзэл санааг нэвтрүүлэх хэрэгтэй ажээ. Ахар богино хугацаанд, тэгэхдээ ул суурьтай, нягт нямбай гаар МАХН-ын түүх, БНМАУ-ын түүх, арван жилийн, дунд, их дээд сургуулиудад заах түүхийн сурах бичгүүдийг шинээр зохион, үзэмжтэй хэвлэх явдал тулгарч байна.

Манай улсын түүх, орчин үеийн социалист байгуулалтын асуудлуудад шинэ байр сууринаас хандах баримжаа чиглэл ямар байх вэ гэвэл:

Нэгд: Улс орныхоо өнгөрсөн түүхэн үйл явдлуудын тухай үнэнийг сэргээн тавих нь чухал байна. Тэгэхдээ үнэн хоёр байдаггүй, ганц байдгийг мартаж болохгүй.

Хоёрт. Манай орны одоогийн социалист байгуулалтын байгаа байдлыг будаж шунхдахгүй, гүн гүнзгий бөгөөд бодитойгоор авч үзэж, шинжлэн дүгнэх;

Гуравт. Улс орныхоо ирээдүйн төлөвийг гярхай нүдээр шинээр харах хэрэгтэй ажээ.

Сүүлийн үе хүртэл манай түүхийн зохиолуудад түүхэн баримт сэлтийг мушгин гуйвуулж, зэрэмдэглэх үзэгдэл үргэлжилсээр ирлээ.

Түүхэнд нэр гарсан Чингис хааныг эсгүл хэрцгий догшин байлдан дагуулагч гэх юм уу, эсгүл бараг зэрлэг хүн шиг үзэж дур мэдэн, түүх гуйвуулан дүрсэлж, түүний үйл ажиллагаа, хувийн зан төрхөд ямар ч дэвшилттэй тал байсангүй гэх мэтээр бичих нь ихэд дэлгэрчээ. Гэтэл, ингэж бичих нь алдас болж, чухамхүү үнэн нь юунд байна вэ гэвэл, Чингис хаан хосгүй стратегич, цэргийн их жанжин, төрийн ухаан төгс зүтгэлтэн байсан бөгөөд олон монгол ястныг нэгтгэж, Монголын их гүрний тулгын чулууг тавьсанд оршино. Түүнчлэн, нөлөө бүхий феодал ноёдыг хавтгайд нь харгис хэмээн дүрсэлж, тэдгээрийн дотор дэвшилтэт үзэлтэй, эх орныхоо төлөө багагүй зүтгэж явсныг нь орхигдуулдаг тал байна. Гэхдээ эх орныхоо түүхийг ангийн үүднээс үзэхийг үгүйсгэж байгаа хэрэг огт биш ээ.

Үүнтэй холбогдуулж нэг зүйлийг анхааруулахад, 1911-1919 оныг хуучин «автономитын үе» гэж нэрлэж байсан явдал ноцтой алдаа мөнийг залруулан засч, «Богд хаант Монгол улс» болгон өөрчлөн, зөв нэр томъёо өгсөн билээ. Ингэж үзэх нь түүхийн баримттай тохирсон, шинжлэх ухаан, улс төрийн утга учрын хувьд зөв зүйтэй шинэ ойлголт болжээ.

Өнөөдрийн Монгол орны амьдралд шинэлэгээр хандах нь одоогийн шатны социалист байгуулалтын тулгамдсан асуудлуудыг бодитой дүгнэн алдсан оносон ололт бэрхшээлийг ил тод хэлэлцэж, зөв шийдвэр гаргах арга замыг хамтын хүчээр боловсруулж байх явдал мөн. Үүнд эрдэм шинжилгээний ажлын гол зорилго чиглэж, улс орныхоо нийгэм-эдийн засгийн хөгжлийн явцыг хурдасгах хамгийн үр ашигтай замыг хайж олоход туслах, чингэхдээ дэлхийн эдийн засгийн интеграцид оролцон, тухайлбал, капиталист орнуудтай хамтын үйлдвэр байгуулах, ард түмнийхээ аж амьдрал, соёл боловсролын хэмжээг мэдэгдэхүйц байнга дээшлүүлэх явдал мөн.

Сүүлийн үе, хүртэл, тухайлбал, манайд өөрчлөн байгуулалт эхлэхийн өмнө тус орны орчин үеийн хөгжлийн тухай өгүүлэхдээ гол төлөв амжилт ололтыг товойлгон, будаж шунхдаж байсан нь санаа амарлингуй байх, нүд хуурах, худал тоо мэдээ гарган сүржигнэх, биеэ дайчлахаас хойш суух, идэвхгүй, золбоогүй байдалд хүргэжээ. Ийм байдал ил тод, ардчилал, өөрчлөн байгуулалттай эрс харш юм. Аливаа байгаа байдлыг будаж шунхдах явдал идэвх зүтгэлтэй санаачилгатайгаар ажил хөдөлмөр хийхэд саад тээр болж, хүний чөлөөтэй сэтгэн бодох авьяас билгийг боогдуулж, нийт хөгжлийг хойш татахад хүргэдэг ажээ.

Ойр болон холын хэтийн төлөвийн тухайд ахул, нийгэм судлаачид улс орныхоо хурдан түргэн бөгөөд зохистой хөгжлийг хангах тийм онолын харилцааг онолын баттай чиг баримжааг боловсруулах үүрэгтэй.

Нам улсын зохион байгуулах ажлыг өөрчлөн байгуулалт ба шинэ ач холбогдолт сэтгэлгээний дагуу шинэ шатнаа гартал эрс сайжруулан өрнүүлэх хэрэгт түүхч, философич, эдийн засагчдын зоригтой онолын сэтгэлгээ шаардагдаж байна. Монгол орон маань XXI зуунд ямар болох тухай сүүл 1970-аад загварыг шинэ сэтгэлгээгээр хамтын хүчээр боловсруулах хэрэгтэй болжээ.

Дээр дурдсан зүйлд нэмж өгүүлэхэд манайд түүхийн зохиол болон сурах бичгүүдэд Чойбалсангийн ролийг түүний буруу зөв үгийн хамт шагшин магтаж, ганц Сталинг шинжлэх ухааны үнэнийг салбар салбараар тодорхойлоход эцсийн үгээ хэлж суудаг ямар нэг ид шид мэт дэвэргэж билээ. Чойбалсан, Сталиныг тахин шүтэх явдал шинжлэх ухааны талбарт ч хүчээр нэвтэрч, тус орны байгаль, нийгмийн шинжлэх ухаанд албадах, захиргаадах, айлган сүрдүүлэх арга, хоосон бясалгал, догматизм дэлгэрч, хөгжилд нь чөдөр тээг болж байжээ.

Нөгөө талаар, түүхийн үйл явдлууд эзэнгүйдэж, хамгийг хөдөлгөгч хүчин нь Сталин, Чойбалсан нар болж хувирчээ.

Түүхийн үнэнийг сэргээх бас нэг чухал асуудал бол хилсээр хэлмэгдэн амь үрэгдсэн манай нам төрийн нэрт зүтгэлтнүүд, түүний дотор ерөнхий сайд Амар, Гэндэн, бүх цэргийн жанжин Дэмид, мөн түүнчлэн энгийн номхон ард иргэдийг нэгийг ч орхилгүй цагаатган, нэр хүндийг нь хэдүй амь буснисан хойно нь ч гэсэн сэргээх нь бүх шударга хүмүүсийн ариун үүрэг мөн. Энэ бол манай нам, засгийн анхаарлын төвд байх ёстой асуудал байна.

Одоо бид сэтгэлд сэв суусан тэр гамшигт үеийн гай уршгаас бүрэн тусгаарлан зааглаж, ард түмнийхээ нэр төр, буурь суурийг гадаад дотоодод хүндэтгэн, эх орныхоо сайн сайхны төлөө гэсэн хэзээ ч шантраагүй эрмэлзлэлийг нь эрхэмлэн дээдэлж байх үүрэгтэй.

ЗӨВЛӨЛТ, ХЯТАДЫН ХАРИЛЦААНЫ ОЛОН МЯНГАН ТҮҮХЭН ШИНЭ ҮЕ

Аргын 1989 он, Билгийн тооллын XVII жарны шаргачин могой жил манай хоёр их хөрш ЗСБНХУ, БНХАУ-ын харилцаанд онцгой жил юм. Энэ онд БНХАУ-ыг тунхагласны 40 жилийн ой, ЗСБНХУ, БНХАУ дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ойг тэмдэглэх болно. Чухам энэ үед ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн дарга, ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн дарга М. С. Горбачев БНХАУ-д албан ёсны айлчлал хийж, хятад улсын нам, төрийн удирдагчидтай уулзаж, хэлэлцээ хийсэн нь удахгүй тэмдэглэх ойнуудыг улам утга төгөлдөр болгох төдийгүй, хоёр улсын харилцааны түүхэн шинэ үеийг нээлээ.